



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2017. 12. 15 № 1-4/4798

танай _____-ны № _____-т

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.МӨРӨН ТАНАА

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны
12 дугаар сарын 11-ний А/295 дугаар тушаалаар
батласан “Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа
зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн санг
ашиглах, мэдээлэл харилцан солилцох журам”-ыг
хүргүүлэв.


Хэрэгжилтийг хангаж, албаны үйл
ажиллагаандаа мөрдөж ажиллана уу.

Хавсралт 6. хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

[Signature]

Г.БАЯСГАЛАН



Батсүх, Батдүвээ, Нармандаа, Баянмөнх, Хөгжимтүвшин
Зарвайн дундагч тасламтуудад.
Дарга нь ирээдүйн хуульчид
уулзаж ажиллахаар. (Ойраг төрөл) 08 5311
[Signature]



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 11 өдөр

Дугаар A/295

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын хилийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсэг, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн санг ашиглах, мэдээлэл харилцан солилцох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газрын дарга /хошууч генерал Ц.Сэргэлэн/, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга /Д.Мөрөн/ нарт үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 2016 оны А/144 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРЧ БАЙГАА ЗОРЧИГЧ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН НЭГДСЭН САНГ АШИГЛАХ, МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАН СОЛИЛЦОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн болон гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн сан бүхий цахим систем /цаашид “цахим систем” гэх/-ийн бүрдүүлэлт, ашиглалт, аюулгүй байдал, хөгжүүлэлт болон байгууллага хооронд мэдээлэл харилцан солилцохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Цахим систем нь төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамаарах бөгөөд мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл нь Төрийн болон албаны нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдана.

1.3.Мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрхтэй байгууллага, албан хаагч нь энэхүү журмыг мөрдөх ба хувь хүний нууц, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн нэгдсэн сан, програм хангамжийг хамгаалах, түүний бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хоёр.Цахим системийн бүтэц, хандах эрхийн зохицуулалт

2.1.Цахим системийг хилийн боомт бүрт зохион байгуулж, дамжуулах байгууламжаар нэгтгэн Хил хамгаалах ерөнхий газарт төвлөрүүлэн холбоно.

2.2.Цахим систем нь дараахь сүлжээ, тоног төхөөрөмж, мэдээллийн сангаас бүрдэнэ:

2.2.1.хилийн боомтуудыг Хил хамгаалах ерөнхий газар болон ашиглах эрх бүхий байгууллагуудтай холбосон сүлжээ;

2.2.2.серверийн байгууламж, компьютер, техник хэрэгсэл, аюулгүй байдлын болон цахилгаан хангамжийн тоног төхөөрөмж;

2.2.3.програм хангамж;

2.2.4.мэдээллийн нэгдсэн сан.

2.3.Цахим системийн ерөнхий хариуцагч нь Хил хамгаалах ерөнхий газар, хэрэглэгч нь цахим системд холбогдож, мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрх авсан байгууллага /цаашид “хэрэглэгч” гэх/ байх бөгөөд Хил хамгаалах ерөнхий газар нь цахим системийн хэвийн, тасралтгүй ажиллагаа, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг Тагнуулын ерөнхий газартай хамтран зохион байгуулна.

2.4.Цахим системд холбогдох хүсэлтийг тухайн байгууллага нь Хил хамгаалах ерөнхий газарт бичгээр гаргана.

2.5.Хил хамгаалах ерөнхий газар нь цахим системд холбогдох хүсэлтийг судлан үзэж, Тагнуулын ерөнхий газрын зөвшөөрлөөр шийдвэрлэнэ.

2.6.Энэ журмын 2.5-д заасан зөвшөөрлийг үндэслэн Хил хамгаалах ерөнхий газар нь хэрэглэгчтэй гэрээ байгуулж, техникийн нөхцөл, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, холбогдох бусад асуудлыг зохион байгуулна.

2.7.Хэрэглэгч нь цахим системд холбогдохдоо шаардлага хангасан компьютер, тусгай зориулалтын техник хэрэгсэл, програм хангамж ашиглах ба шаардагдах техник хэрэгсэл, харилцан холболтын зардлаа хариуцна.

Гурав.Цахим системийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах

3.1.Улсын хил хамгаалах байгууллага болон Гадаадын иргэн, харьяатын газар нь тус тусын мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэгч байна.

3.2.Мэдээллийн нэгдсэн сан дараахь мэдээллээс бүрдэнэ:

3.2.1.зорчигч, тээврийн хэрэгслийн хил нэвтрэлтийн;

3.2.2.саатуулах зорчигчийн;

3.2.3.гадаадын иргэний бүртгэлийн;

3.3.Улсын хил хамгаалах байгууллага мэдээллийн нэгдсэн санд дараахь мэдээллийг оруулна. Үүнд:

3.3.1.зорчигч, тээврийн хэрэгслийн хил нэвтрэлтийн;

3.3.2.саатуулах зорчигчийн;

3.4.Гадаадын иргэн, харьяатын газар мэдээллийн нэгдсэн санд гадаадын иргэнтэй холбогдох дараахь мэдээллийг оруулна. Үүнд:

3.4.1.гадаадын иргэнд олгосон Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрлийн;

3.4.2.захиргааны шийтгэл хүлээсэн иргэн, хуулийн этгээд, Монгол Улсаас албадан гаргагдаж тус улсад орохыг хориглосон болон Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэний талаарх мэдээлэл;

3.4.3.гадаадын болон Монгол Улсын иргэний харьяаллын болон Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсэн талаарх мэдээлэл;

3.4.4.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын мэдээлэл.

3.5.Мэдээллийн нэгдсэн сангийн дор дурдсан мэдээллийг дараахь байгууллагууд албан хэрэгцээнд ашиглана:

3.5.1.Улсын хил хамгаалах байгууллага нь өөрийн бүрдүүлснээс гадна:

3.5.1.а/.Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн, албадан гаргагдсан, тус улсад орохыг хориглосон гадаадын иргэдийн мэдээлэл;

3.5.1.б/.гадаадын иргэдэд олгосон Монгол Улсын виз, оршин суух бүртгэлийн зөвшөөрөл, урилгын мэдээлэл;

3.5.1.в/.Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсэн тухай мэдээлэл;

3.5.2.Гадаадын иргэн, харьяатын газар нь өөрийн бүрдүүлснээс гадна:

3.5.2.а/.Монгол Улсын хилээр нэвтэрсэн гадаадын иргэдийн мэдээлэл;

3.5.3.хэрэглэгч хууль, захиргааны хэм хэмжээний актад заасан чиг үүрэгт хамаарах мэдээлэл.

3.6.Зорчигчийг улсын хилээр шалган нэвтрүүлэхэд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Монгол Улсын иргэний үндсэн болон бусад шаардлагатай мэдээллийн санг ашиглана.

Дөрөв.Мэдээллийн нэгдсэн сангийн байршил

4.1.Мэдээллийн нэгдсэн сангийн үндсэн серверийн байгууламж, цахилгаан хангамж, холболтын техник хэрэгслүүдийг Хил хамгаалах ерөнхий газарт тусгайлан бэлтгэсэн өрөө, зогсуурт байршуулах ба цахилгаан хангамж нь хоёр талын тэжээлтэй, нөөц цахилгаан үүсгүүртэй байна.

4.2.Мэдээллийн нэгдсэн сангийн нөөц серверийг "Үндэсний дата төв" улсын төсөвт үйлдвэрийн газарт байршуулна.

Тав.Мэдээллийн нэгдсэн санд хандах эрхийн зохицуулалт, мэдээлэл харилцан солилцох

5.1.Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэгч байгууллага нь өөрийн бүрдүүлсэн мэдээлэлд хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөлт оруулах эрхтэй ба бусад мэдээллийн санг зөвхөн зориулалтаар нь ашиглах эрхтэй байна.

5.2.Хэрэглэгч мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг зөвхөн зориулалтаар нь ашиглах эрхтэй байна.

5.3.Мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрх олгох, цуцлах асуудлыг хэрэглэгчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтны бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн Хил хамгаалах ерөнхий газар Тагнуулын ерөнхий газартай хамтарч шийдвэрлэнэ.

5.4.Албан тушаалтны мэдээллийн нэгдсэн санд хандах эрхийг цуцалсан тохиолдолд өмнөх хандалтын бүртгэлийг хадгална.

5.5.Мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх албан тушаалтан өөрчлөгдөх тохиолдолд журмын 5.3 дахь заалтыг баримтална.

5.6.Цахим систем нь мэдээллийн нэгдсэн сангийн өөрчлөлт, ашиглалт, хандалтыг түүхчилсэн бүртгэл /log/-д автоматаар бүртгэдэг байна.

Зургаа.Цахим системд холбогдсон байгууллагын үүрэг

6.1.Цахим системд холбогдсон байгууллага дор дурдсан нийтлэг үүрэг хүлээнэ;

6.1.1.мэдээллийн нэгдсэн сан ашиглах, мэдээлэл харилцан солилцохдоо Засгийн газрын 2017 оны 159 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг баримтлах;

6.1.2.цахим системийн програм хангамж, сүлжээ, тоног төхөөрөмжүүдийн технологийн горимыг сахих;

6.1.3.цахим системийн сүлжээг байгууллагын албаны дотоод сүлжээнээс тусгаарлах;

6.1.4.техникийн аюулгүйн арга хэмжээг хэрэгжүүлэх, цахим системийн програм хангамж, сүлжээ, тоног төхөөрөмжүүдийг гадны нөлөөллөөс хамгаалах;

6.1.5.өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн цахим системийг ашиглах дотоод журам боловсруулж мөрдөх;

6.2.Цахим системийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэгч байгууллага нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

6.2.1.өөрийн бүрдүүлсэн мэдээллийн сангийн үнэн зөв, бүрэн бүтэн байх, сүлжээний хэвийн, тасралтгүй ажиллагааг хангах;

6.2.2.цахим системийн аюулгүй байдал, програм хангамжийн хөгжүүлэлт, албан ёсны зөвшөөрөл, лиценз болон сүлжээний сувгийн зардлыг байгууллагын төсөвт тусгуулах;

6.2.3.цахим системийн ажиллагаа доголдсон үед бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэвийн явуулах арга ажиллагаа, журмыг тогтоож, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

6.2.4.цахим системд өөрийн бүрдүүлсэн мэдээллийн нэгдсэн сангаас холбогдох хууль тогтоомжийн дагуу лавлагаа, мэдээллийг олгох;

Долоо.Цахим системийн сайжруулалт, хөгжүүлэлт

7.1.Сервер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг таван жил тутам /шаардлагатай тохиолдолд тухай бүр/ шинэчилнэ.

7.2.Хэрэглэгч байгууллагууд мэдээллийн нэгдсэн сангийн програм хангамжийг албаны шаардлагад нийцүүлэн тогтмол сайжруулах, хөгжүүлнэ.

7.3.Хил хамгаалах ерөнхий газар нь цахим системийн өөрчлөлт, хөгжүүлэлт, мониторинг, үнэлгээг хийлгэх, ре-инженеринг хийхэд систем зохиомжлох чадвартай хуулийн этгээдтэй хамтран шийдвэрлэх, зөвлөх үйлчилгээ авна.

Найм.Хориглох зүйл

8.1.Цахим системийг ашиглахтай холбоотойгоор эрх бүхий байгууллагад дараахь үйл ажиллагааг хориглоно:

8.1.1.цахим системд хандах эрхийг нээх, цуцлах тухай шийдвэрийг амаар өгөх;

8.1.2.эрх бүхий албан тушаалтнаас өөр хүн ажиллуулах;

8.1.3.техник хэрэгслийг интернэтийн болон зориулалтын бус сүлжээнд холбох;

8.1.4.цахим системд холбогдсон сервер, бүртгэлийн компьютер, програм хангамжийг өөр зориулалтаар ашиглах, системийн зориулалтаас өөр үйлчилгээ /service/-г ажиллуулах;

8.1.5.цахим системийн сүлжээгээр теле хурал хийх зэрэг сүлжээг зориулалтын бусаар ашиглах;

8.1.6.мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэгч байгууллагын зөвшөөрөлгүйгээр мэдээллийг хуулбарлах, бусдад задруулах;

8.1.7.цахим системийн програм хангамжийг хувилан тараах, бусдад шилжүүлэх;

8.1.8.Тагнуулын ерөнхий газраас тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаагүй, нууцын баталгаа өгөөгүй хувь хүн, хуулийн этгээдийг цахим системийн хөгжүүлэлтэд оролцуулах.

Ес.Хяналт, үнэлгээ

9.1.Журмын хэрэгжилтэд хяналт тавих, мониторинг, үнэлгээ хийх асуудлыг Тагнуулын ерөнхий газрын харьяа Төрийн мэдээлэл холбооны газар хариуцна.

---oOo---